



# МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

# СОЁМБОМ ЭДЭЭ

№187 /397/ 2022.10.18

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ШИНЭ СУРГУУЛИЙН ЖИЛИЙН НЭЭЛТ БОЛЛОО

Зэвсэгт хүчний 2022-2023 оны шинэ сургуулийн жилийн нээлт боллоо.

Нээлтийн ажиллагаанд ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба, Сургалт бэлтгэлийн газрын дарга бригадын генерал Г.Болор, Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газрын удирдлагууд болон Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын захирагч дарга, бие бүрэлдэхүүн цахимаар оролцлоо.

Бригадын генерал Г.Болор сургуулийн жилийг нээж хэлсэн үгэндээ “Бид дэлхий нийтийн өөрчлөлт, шинэчлэлт, сорилт, шийдлийн эрэл хайгуултай шийдвэрлэх цаг үед амьдарч байна. Тэр дундаа Зэвсэгт хүчний бүрэлдэхүүний өмнө бодлогоо оновчтой тодорхойлох, зөв бүтэц, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх, удирдлагын менежментийг сайжруулах, технологийн дэвшлийг өргөн ашиглах, хүний нөөцийн ур чадвараа, алба хаагчдынхаа сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зэрэг олон асуудал бидний өмнө тулгарч байна.

Энэ хүрээнд бид Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, “Батлан хамгаалах бодлогын үндэс”, Зэвсэгт хүчний хөгжлийн стратегид тулгуурласан Монгол Улс мэргэжлийн цэрэгт суурилсан чадварлаг Зэвсэгт хүчнийг бүрдүүлж, бэхжүүлнэ гэсэн үзэл баримтлалын дагуу өнөөдөр цэргийн сургалт бэлтгэлийн бодлогоо тодорхойлон эрхзүйн шинэчлэлт хийж, төрлийн цэргийн командлалууд байгуулагдсаны үндсэн дээр цэргийн сургалт бэлтгэлийн тогтолцоонд өөрчлөлт

орж, цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн тогтолцоо болон төрлийн цэргийн командуудын дэд тогтолцоо үүсэн зэрэг олон шинэ амжилттайгаар Зэвсэгт хүчний 2022-2023 оны сургуулийн жилийг эхлүүлж байна. Та бүхний өмөн хүлээгдсэн Зэвсэгт хүчний шинэчлэлийн бодлогыг гүнзгийрүүлэх, үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх зэрэг томоохон зорилтуудыг ажил хэрэг болгоход ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалууд, нэгтгэл, анги байгууллага, бие бүрэлдэхүүний гүйцэтгэх үүрэг, оролцоо ихээхэн ач холбогдолтой бөгөөд бид бүхний хичээл зүтгэл цэргийн сургалт бэлтгэлээр дамжуулан Зэвсэгт хүчний бэлэн байдлыг хангахад үнэтэй хувь нэмрээ оруулна. Зэвсэгт хүчний үүрэг, оролцоо есөн нэмэгдэж байгаа хариуцлагатай энэ цаг үед Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, бие бүрэлдэхүүний гүйцэтгэх үүрэг үлэмж их бөгөөд мэдлэг, чадвар туршлагаараа ямагт манлайлж өөрийгөө болон бусдыг хөгжүүлэх асуудалд онцгой анхаарах нь чухал” гэлээ.

Мөн 2022-2023 оны сургуулийн жилийг “Залуу офицеруудын манлайлал”-ын жил болгон зарласантай холбогдуулан бие бүрэлдэхүүний үнэт зүйлсийг тодорхойлж, цэргийн сургалт бэлтгэлд шинэлэг арга технологийг ашиглаж манлайлагч байхыг хүсье гэв.

Үргэлжлүүлэн ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын даргын орлогч, хэлтсийн дарга хурандаа Д.Жигжидсүрэн Зэвсэгт хүчний 2022-2023 оны сургуулийн жилийн зорилго, зорилт үйл ажиллагааны талаар танилцууллаа.



Энэ үеэр Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчний бэлэн байдлыг хангах үндэс нь цэргийн сургалт бэлтгэлийн цогц үйл ажиллагаа гэдгийг онцлов.

Энэхүү цогц үйл ажиллагаа нь анги байгууллага дээр явагдах албан болон албан бус сургалтыг өдөр тутмын үйл ажиллагаатай уялдуулан, сэтгэл зүйн нэгдлийг зохион байгуулснаар хангагдана.

Иймд бүх шатны сургалт бэлтгэлийг үр дүнтэй зохион байгуулж явуулахад салбар, нэгжээс эхлэн удирдлагын байгууллага хүртэл идэвхтэй ажиллаж “Бэлэн байх” үүргээ биелүүлцгээе хэмээн ЗХЖШ-аас уриалав.

Төгсгөлд нь ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба шинэ сургуулийн

жилийн нээлтийн ажиллагаанд оролцсон бүрэлдэхүүнд албан даалгавар, үүрэг чиглэл өгсөн юм.

Тэрээр хэлсэн үгэндээ “Бид бүхэн “Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн ерөнхий журам” баримт бичгийг боловсруулан баталснаар цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн тогтолцоог шинэчлэн тодорхойллоо. Ингэснээр бид Төрлийн цэргийн командлалуудын түвшинд “Цэргийн сургалт бэлтгэлийн заавар” болон удирдлага, зохион байгуулалтын бусад баримт бичгүүдийг боловсруулан хэрэгжүүлснээр цэргийн сургалтын агуулга, зохион байгуулалт шинэчлэгдэж, Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх, бэхжүүлэх үндсэн зорилгодоо хүрэх болно” гэдгийг онцоллоо.

ДЭСЛЭГЧ Ц.ЭНХ-ОРГИЛ

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 13	☁️ -2

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 32	☁️ 23

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.415.00	3.428.0
EUR 🇪🇺	3.340.0	3.360.0
CNY 🇨🇳	475	480
RUB 🇷🇺	51.40	51.90
JPY 🇯🇵	23.30	24.10
KRW 🇰🇷	2.43	2.47

### ЗУРХАЙ



2022.10.18 /МЯГМАР ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 23

**НАМРЫН ДУНД САРЫН ШАРАГЧИН ТАХИА САР ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ХӨХ ЛУУ ӨДӨР**

**Үс засуулбал:**  
Эд эдлэл идээ ундаа олдоно  
**НАРАН УРГАХ, ШИНГЭХ:**  
07.15-17.59

**Барилдлага:**  
Арвидах  
**Шүтэн барилдлага:**  
Хуран үйлдэхүй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр идээ, хувцас хунар олдох, худалдаа наймаа хийх, эд зүйлс өгөлцөж авах, өглөг өгөх, хөрөнгө цацах, эдийн тэнгэр тахиулах, шид бүтээл үйлдэхэд сайн. Зүүн нүд татвал үзэсгэлэн болох, баруун нүд татвал үйл өчүүхэн бүтэх, баруун чих хангинавал гоо болох, зүүн чих хангинавал сайн. Нохой уливал хааны хэрэг болох, хэрээ дуугарвал өөрийн цусыг үзэх, тагнай загатнавал гэрт үзэсгэлэн болох, бүх бие татвал эд алдах, хөлийн мах татвал сайн гэдэг.

## ТӨРИЙН ЁСЛОЛЫН ЦЭРГИЙН ЦАГААН ТУГАНДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



Цэргийн гавьяаны улаан тугийн болон Байлдааны гавьяаны одонт, хурандаа генерал Ж.Ёндонгийн нэрэмжит Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах Зэвсэгт хүчний 032 дугаар ангид 2021 онд хугацаат цэргийн албанд татагдсан дайчид өнөөдөр Төрийн ёслолын цэргийн цагаан тугандаа хүндэтгэл үзүүлэн бэлтгэлээр ёслол төгөлдөр халагдлаа. Бэлтгэлээр

халагдсан байлдагчдыг хүндэтгэлийн Монгол Улсын хонжин, захирагчаар ажиллаж бэлтгэл бригадын генерал Г.Энхбаатар, Монгол Улсын төрийн хонжин, Хүндэт харуулын тусгай ротын 17 дахь захирагч бэлтгэл хурандаа Ч.Дүүрэнжаргал, Хүндэт харуулын тусгай ротын 18 дахь захирагч бэлтгэл хурандаа Өнөрсайхан, “Хүндэт харуул” ТББ-

түрүүч, үдэх ёслолд төрийн ангийн ажиллаж бэлтгэл генерал Монгол Ё.Наранцэцэг нар хүндэт зочноор оролцлоо.

Ангийн захирагч хурандаа М.Болдбаатар “Амьдралын их далайд гарч, ажил хөдөлмөрөө эрхлэн явахдаа Монгол Улсын Зэвсэгт хүчин, анги байгууллагынхаа нэр хүндийг өндөрт

өргөж, ард иргэдэд эергээр сурталчилж, дайчин замналтай төрийн торгон цэргийн ангид алба хааснаараа бахархаж явах учиртай” хэмээн хэлсэн үгэндээ онцолсон юм.

Дайчдыг төлөөлж, Хүндэт харуулын тусгай ротын байлдагч Б.Азжаргал “Цэргийн албанд сурсан мэдсэн зүйлээ туулж өнгөрүүлэх амьдралынхаа тулгуур багана нь болгож, зөв сэтгэлгээтэй, гэгээлэг үйлстэй, эх орныхоо

төлөө үнэнч шударгаар хөдөлмөрлөсөн иргэн байцгаая” хэмээн дайчин нөхдөө уриаллаа. Бэлтгэлээр халагдсан дайчдыг “Онц сурлагатан”, “Онц буудагч”, “Тамирчин дайчин” тэмдэг болон Төрийн ёслолын цэргийн цагаан тугийн өмнө авхуулсан гэрэл зураг, ар гэрт нь илгээх талархлын захидал, “Торгон цэрэг” дурсамж, “Жагсаалч Ёндон” сангийн нэрэмжит шагнал зэрэг

шагнал урамшууллаар мялаасан юм. Уг ёслолын ажиллагааг 9 дүгээр сард төрсөн хугацаат цэргийн алба хаагчдын төрсөн өдрийг тэмдэглэх “Халагдах цэргийн вальс” цэнгүүнээр үргэлжлүүлж, ангийн үлээвэр найрал хөгжмийн бүрэлдэхүүн, салбарын офицер, ахлагч нар тэдэнд урлагийн тоглолтоор баярын мэнд хүргэж, мэндчилгээ дэвшүүлэв. АХМАДТ.ДЭЛГЭРМАА



### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 630,111,004

Эдгэрсэн

Нийт: 609,382,386

Нас барсан

Нийт: 6,572,515

Сэтгэгдэл

# ЭХ ОРНЫ ХҮҮ БОЛЖ ЭРЭЛХЭГ ЗАЛУУСААС ИХИЙГ СУРЧ АВААРЙ



Юуны өмнө Монгол улсын үндсэн хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ үнэнчээр биелүүлж жилийн хугацаат цэргийн алба амжилттай хаасан нийт ХЦАД-даа баяр хүргэе. Би Дундговь аймгийн Эрдэнэдалай суманд төрж өссөн. 2017-2021 онд ШУТИС-ийг Авто инженер мэргэжлээр төгсөөд хугацаат цэргийн албандаа татагдан ирсэн. Алдар цуут тусгай хороонд цэргийн алба хаасандаа баяртай байна. Байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх, бэлтгэлээр халагдах ёслолын ажиллагаа бол дайчид бидний хувьд насан туршийн дурсамж хамгийн том бахархлын өдөр юм. Хэзээ ч мартаггүй санаж бодох бүртээ эх орны эр цэрэг байж алба нэр төртэй хаасандаа бахархаж омогшиж явах болно.

**-Халагдаж очоод хамгийн түрүүнд юу хийх вэ?**  
Хайртай ээждээ очиж үнсүүлнэ ээ. Цэрэгт байхдаа ээжтэйгээ захиагаар харьцаж байлаа. Ярьснаас илүү сэтгэл санаа болон хэлэх гэсэн бүхнээ уудалдаг юм билээ. Тийм учраас ээждээ захиа бичих дуртай болсон. Шуудангаас хариу ирэхийг тэсэн ядан хүлээдэг байв.

**-Цэргийн алба хаах хугацаанд**

**баярлаж талархсан сэтгэгдлээ илэрхийлбэл ?**  
Алба хаах хугацаанд бидэнд бүх зүйлийг зааж зөвлөн сургаж хүмүүжүүлсэн эрхэм офицер, ахлагч нар тэр дундаа Ахмад Б.Болд-Эрдэнэ захирагчтай I мотобуудлагын ротын хамт олон, салааны захирагч дэслэгч Г.Пүрэвдорж, ротын ахлагч ахлах ахлагч Ч.Баттулга, соёл хүмүүжлийн зааварлагч дэслэгч Б.Батзаяа болон МББ-ы хамт олондоо нийт алба хаасан ХЦАХ-дынхаа өмнөөс баярласан талархсанаа илэрхийлж байна. Та бүгдийн цаашдын ажил, амьдралд тань аз жаргалын дээдийг хүсэн ерөөе. Их говийн хорооноос сурсан бүхнээ цаашид амьдралдаа мөрдлөг болгон хэрэгжүүлэх болно оо.

Энэ завшааныг ашиглаад дүү нартаа хандаж хэлэхэд эр хүн, эрхэм дүү нар минь эх орны хүү болж амьдралын их сургууль болсон цэргийн хуаран, эрлэхг залуусаас ихийг сурч аваарай. Бүү няцаарай. Бүү шантраарай. Бүү эмээгээрэй гэж хэлмээр байна.

Монгол цэргийн мэлмий тунгалаг, өлмий бат оршиг

**ДЭД ТҮРҮҮЧ Б.МӨНХБААТАР**

## ЭРДЭМТЭН, СУДЛААЧИД ЧУУЛЛАА



Өнөөдөр Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, Монгол цэргийн нэгдсэн холбоо, Олон улс Монгол судлалын холбоо, ШУА-ийн түүх, угсаатны зүйн хүрээлэн, Философийн хүрээлэн хамтран “Үндэсний ой санамж ба үндэсний аюулгүй байдал” эрдэм шинжилгээний хурлыг ҮБХИС-ийн Сүбээдэй танхимд зохион байгууллаа.

Тус эрдэм шинжилгээний хуралд Ерөнхийлөгчийн тагмын газар, Аюулгүй байдлын зөвлөл, Соёлын яам, Батлан хамгаалах яам, Батлан хамгаалахын

Эрдэм шинжилгээний хүрээлэн, Монгол цэргийн нэгдсэн холбоо, Олон улс Монгол судлалын холбоо, ШУА-ийн Философийн хүрээлэн, Түүх угсаатны зүйн хүрээлэн, Их дээд сургуулиудын төлөөлөл эрдэмтэн, судлаачид оролцсон бөгөөд нийт 10 гаруй лекц, илтгэлийг тодорхой сэдвүүдийн хүрээнд танилцуулсан юм.

Хурлын төгсгөлд эрдэм шинжилгээний хуралд оролцогч эрдэмтэн, судлаачид хуралд оролцогч газар, Аюулгүй байдлын нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж санал бодлоо солилцсон юм.

## СУРГУУЛИЙН ЖИЛИЙН НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 186 дугаар анги 2022-2023 оны сургуулийн жилийн хичээлийн шинэ жилийн нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа.

Бие бүрэлдэхүүн цугларах дохиогоор ажиллаж аранз, хүн нэг бүрийн байлдааны хувийн хэрэгсэл, бичиг баримтын үзлэгт хамрагдсаны дараагаар ЗХЖШ-ын нэгдсэн цахим нээлтийн арга хэмжээнд оролцсон юм.

Цуглааны ажиллагааг "Цэргийн сургалт бэлтгэл зохион байгуулах" тухай ангийн захирагчийн тушаалыг унжиж танилцуулснаар эхлүүлж, захирагч хурандаа Ц.Төрмөнх бие бүрэлдэхүүнд энэ сургуулийн жилийн

зорилго, зорилт дээд удирдлагаас баримтлах бодлогыг сануулж, амжилт хүссэн бол Мотобуудлагын батальоны салааны захирагч дэслэгч Б.Майдаржав хариуцсан салааны бие бүрэлдэхүүнээ бие бялдар, сэтгэлзүйн хувьд хөгжүүлэхээ анхаарч ажиллахын зэрэгцээ Зэвсэгт хүчний манлайлагч залуу офицер байхыг эрмэлзэн ажиллахаа хэлсэн юм.

Мөн тус арга хэмжээний хүрээнд Хуурай замын цэргийн командлагчийн тушаалаар цэргийн цол нэмсэн цэргийн алба хаагчдад цэргийн цол олголоо.

**Хошууч О.ОТГОНЦЭЦЭГ**

## ЦЭРГИЙН АЛБАНЫ НЭР ХҮНДИЙГ ӨНДӨРТ ӨРГӨЖ ЯВНА ГЭВ



Зэвсэгт хүчний 120 дугаар ангид 2021 оны хоёрдугаар ээлжээр татагдан ирсэн хугацаат цэргийн алба хаагчдыг бэлтгэлээр халах ёслолын

ажиллагааг 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр амжилттай зохион байгууллаа.

Тус арга хэмжээний үеэр ангийн захирагч хурандаа

Л.Дагвасүрэн баяр хүргэж үг хэлэхдээ цэргийн албаны нэр хүндийг өндөрт өргөн, үргэлж эергээр сурталчилж явахыг захисан юм.

Мөн нийт халагдаж буй дайчдадаа баяр хүргэж, 2021 оны тэргүүний байлдагч, ахлах байлдагч СУИС-ийн уртын дуулаачийн 1 дүгээр курсийн оюутан Э.Содболд ая дууны мэндчилгээ өргөн дэвшүүлэв.

**Хошууч Ө.Нарантуяа**

## САЛБАРЫН ЗАХИРАГЧ НАРЫН ЦУГЛАРАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



2022-2023 оны шинэ сургуулийн жилийг угтан Зэвсэгт хүчний 065 дугаар анги хөдөө орон нутагт байрлах байгууламж, тусгай ротын захирагч нарын дунд "Цэргийн бүлэглэлийг агаарын цагийн байдлын мэдээгээр хангах үеийн байгууламж, тусгай ротын харилцан ажиллагааг төлөвлөх

нь" сэдэвт "Заах аргын цугларалт"-ыг амжилттай зохион байгууллаа.

Цугларалтын хүрээнд шинжлэх ухааны үндэслэлтэй орчин үеийн технологийн ололт, инновацыг сургалтад нэвтрүүлэх, холбоо мэдээллийн дэвшилтэт технологид суурилсан цахим сургалтын орчинг

бүрдүүлэх, ЦАХ-д бие даан сурах арга зүй, ур чадварыг эзэмшүүлэх, хандлага, ур чадвартай мэргэшсэн ЦАХ-дыг бэлтгэх, цахим сургалтын арга, хэлбэрийг цэргийн сургалт бэлтгэлд нэвтрүүлэх, сургалтын материаллаг баазыг сайжруулах талаар хэлэлцэж санал солилцсон юм.

## Сургалт МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №06

**СҮҮЛ**  
Хэрэм, муур, имж зэрэг амьтны сүүлний үзүүр аажим нарийсан торгон үзүүртэй болж төгссөн байдаг.

Түүнтэй төстэй зурлага юм. Үгийн төгсгөлд орох А, Э эгшиг болон На дэвсгэр, мөн Да дэвсгэрийн бүтцэд сүүл махбод ордог.

Сүүлийг бичихдээ, хоёр гэдэсний хэрийн урт нуруу татаад нар буруу эргүүлэн ялимгүй дээш эргүүлсхийн төгсгөдөг. Үзүүрийг нарийн, уран гаргах нь чухал. Үүний тулд, үзэг барьсан хурууныхаа даралтыг багасган огцом орхиж төгсгөнө.

Олон удаа давтан бичиж байж сүүл зурлага төгс сайхан хэлбэрийг олмуй.

Өргөн нь хамгийн баруун захын шугамаас хэтрэхгүй.

